



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.АМАРСАНАА ТАНАА

2025.02.25 № 007-2025/122/НА-ОТН-743
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/102 дугаар тушаалын 10 дахь заалтууд болон ЭМС, БШУСС-ын 2018 оны А/494, А/761 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралттай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Толилуулга" "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр ур чадварын нэмэгдэл илүү олгосон,
- Хамтын гэрээнд тусгасан гэх үндэслэлээр эмчийн ажлын байрны тодорхойлод заагдсан шаардлагыг хангаагүй, эмчийн мэргэжилгүй нярвын

432502258

- албан тушаалд ажиллаж буй албан хаагчаар эмчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, цалин олгосон,
- Өөрийн хамаарал бүхий этгээд /төрсөн хүүхэд/-ийг арга зүйчээр хавсран ажиллуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн,
 - Хүүхдийн ирцийг бодитоор тооцолгүйгээр өдөр бүр ирвэл зохих бүх хүүхдээр тооцон хоолны материалыг зарлагдсан,
 - Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас хүнсний материалын өр төлбөр үүсгэсэн,
 - Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Асуудлын онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу цэцэрлэгийн шинэ байрны барилга болон бусад дагалдах үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч санхүүгийн данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	271,683,279.52	282,984,249.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	210,964,608.44	178,600,686.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	210,964,608.44	178,600,686.38
3121	Төгрөг	210,964,608.44	178,600,686.38
31211	Төрийн сангийн харилцах	210,964,608.44	178,600,686.38
33	АВЛАГА	-	15,082.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	15,082.75
35	БАРАА МАТЕРИАЛ	60,718,671.08	104,368,480.02
354	Хангамжийн материал	60,718,671.08	104,368,480.02
35410	Бичиг хэргийн материал	58,000.00	189,000.00
35420	Аж ахуйн материал	160,000.00	50,000.00
35460	Хүнсний материал	404,000.00	148,750.00
35470	Бусад хангамжийн материал	60,096,671.08	103,980,730.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,336,298,861.97	7,921,962,784.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,336,298,861.97	7,921,962,784.02
392	Биет хөрөнгө	1,251,595,612.20	7,729,722,534.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,403,592,874.13	7,019,841,443.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(249,085,610.51)	(291,490,639.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	178,494,482.77	213,569,696.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(120,756,152.53)	(137,730,298.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,001,115.15	198,383,874.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(143,432,215.53)	(152,387,629.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	138,016,953.93	1,010,500,350.93
39215	Хуримтлагдсан элэгдэл	(132,948,946.39)	(134,677,373.68)
39217	Ном	3,713,111.18	3,713,111.18
393	Биет бус хөрөнгө	84,703,249.77	192,240,249.69
39301	Программ хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(818,750.23)	(993,750.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	83,772,000.00	191,484,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,607,982,141.49	8,204,947,033.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,877,589.61	5,058,418.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,877,589.61	5,058,418.05
413	Өглөг	5,877,589.61	5,058,418.05
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	107,520.05
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,875,445.00	3,504,205.00
4136	Бусад өглөг	2,144.61	1,446,693.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,446,693.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,602,104,551.88	8,199,888,615.12
51	Засгийн газрын хувь оролцоо	1,602,104,551.88	8,199,888,615.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	743,888,652.88	743,888,652.88
51101	Өмч: - төрийн	743,888,652.88	743,888,652.88
512	Хуримтлагдсан үр дүн	(183,403,697.72)	6,414,380,365.52
51210	Өмнөх үеийн үр дүн	(335,307,697.10)	(183,401,553.11)

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51220	Тайлант үеийн үр дүн	151,903,558.38	6,597,781,918.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,041,619,596.72	1,041,619,596.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,607,982,141.49	8,204,947,033.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,615,399,508.55	8,575,107,172.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,485,896.00	6,680,436,197.85
120	Нийтлэг татварын бус орлого	50,485,896.00	6,680,436,197.85
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	28,552,326.00	6,650,348,138.91
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	16,956,370.00	30,088,058.94
120009	Бусад орлого	4,977,200.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,564,913,612.55	1,894,670,975.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,441,733,900.00	1,733,757,475.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,441,733,900.00	1,729,713,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	4,044,375.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,179,712.55	160,913,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,179,712.55	160,913,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,463,495,950.17	1,977,325,254.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,463,495,950.17	1,977,325,254.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,463,495,950.17	1,964,346,354.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	955,561,114.09	1,355,379,544.23
210101	Үндсэн цалин	729,064,310.79	915,881,009.60
210102	Нэмэгдэл	195,502,021.95	372,956,184.63
210104	Урамшуулал	30,994,781.35	66,542,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,118,074.29	169,878,620.13
210201	Тэтгэврийн даатгал	84,044,906.56	118,092,509.60
210202	Тэтгэмжийн даатгал	9,906,505.43	13,871,786.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,700,124.73	6,979,827.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,754,757.17	6,259,096.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,711,780.40	24,675,400.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,180,012.55	135,913,500.00
210301	Гэрэл, цахилгаан	14,545,109.93	15,862,059.87
210302	Түлш, халаалт	78,201,242.62	94,714,064.00
210303	Цэвэр, бохир ус	21,433,660.00	25,337,376.13
2104	Хангамж, бараа материалын задал	11,37,500.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	11,307,500	-
2105	Нормативт зардал	143,555,425.00	170,235,280.00
210502	Хоол, хүнс	143,555,425.00	170,235,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	18,270,000.00
210604	Урсгал засвар	0.00	18,270,000.00

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,654,593.00	3,955,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,654,593.00	3,955,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,119,231.24	110,713,609.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,410,945.00	28,236,643.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,100,890.00	12,238,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,607,396.24	70,238,016.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	12,978,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	12,978,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	12,978,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	151,903,558.38	6,597,781,918.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	151,903,558.38	6,597,781,918.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,569,890,812.55	1,894,670,975.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,977,200.00	
120	Нийтлэг тативарын бус орлого	4,977,200.00	
120009	Бусад орлого	4,977,200.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,564,913,612.55	1,894,670,975.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,441,733,900.00	1,733,757,475.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,441,733,900.00	1,729,713,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	4,044,375.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,179,712.55	160,913,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,179,712.55	160,913,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,373,977,981.19	1,921,481,097.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,373,977,981.19	1,921,481,097.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,373,977,981.19	1,908,502,197.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	950,223,728.87	1,355,287,106.72
210101	Үндсэн цалин	706,495,405.37	915,788,572.09
210102	Нэмэгдэл	211,723,489.74	372,956,184.83
210104	Урамшуулал	32,004,833.76	66,542,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,115,606.77	169,878,620.14
210201	Тэтгэврийн даатгал	84,353,688.77	118,092,509.60
210202	Тэтгэмжийн даатгал	9,953,567.27	13,871,786.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,589,724.42	6,979,827.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,026,574.34	6,259,096.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,192,051.97	24,675,400.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,180,012.55	135,913,500.00
210301	Гэрэл, цахилгаан	14,545,109.93	15,862,059.87
210302	Түлш, халаалт	78,201,242.62	94,714,064.00
210303	Цэвэр, бохир ус	21,433,660.00	25,337,376.13
2105	Нормативт зардал	143,751,455.00	172,299,270.00
210502	Хоол, хүнс	143,751,455.00	172,299,270.00

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,999,700.00	25,000,000.00
210604	Урсгал засвар	8,999,700.00	25,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,611,000.00	3,955,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,611,000.00	3,955,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,096,478.00	46,167,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,263,578.00	33,649,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,832,900.00	12,518,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	12,978,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,978,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	12,978,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	195,912,831.36	(26,810,122.06)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,360,400.00	5,553,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,360,400.00	5,553,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,360,400.00	5,553,800.00
222001	Тоног төхөөрөмж	6,144,400.00	5,553,800.00
223001	Бусад хөрөнгө	216,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,360,400.00)	(5,553,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	189,552,431.36	(32,393,922.06)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,412,177.08	210,964,608.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	210,964,608.44	178,600,686.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,888,652.88	1,041,619,596.72	(335,307,256.10)	1,450,200,993.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	743,888,652.88	1,041,619,596.72	(335,307,256.10)	1,450,200,993.50
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	151,903,558.38	151,903,558.38
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,888,652.88	1,041,619,596.72	(183,403,697.72)	1,602,104,551.88
D01	2024 оны 1-р сарын 1-	743,888,652.88	1,041,619,596.72	(183,403,697.72)	1,602,104,551.88

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	нээрх үлдэгдэл				
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-	2,144.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	743,888,652.88	1,041,619,596.72	(183,401,553.11)	1,602,106,696.49
D08	Тайлант үеийн үр дүн		-	6,597,781,918.63	6,597,781,918.63
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,888,652.88	1,041,619,596.72	6,414,380,365.52	8,199,888,615.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,105,635,600.00	1,927,034,897.06	178,600,702.94	91.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,105,635,600.00	1,927,034,897.06	178,600,702.94	91.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,092,656,700.00	1,914,055,997.06	178,600,702.94	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,516,784,700.00	1,355,287,106.92	161,497,593.08	89.4
210101	Үндсэн цалин	1,042,464,300.00	915,788,572.09	126,675,727.91	87.8
210102	Нэмэгдэл	422,786,100.00	372,956,184.83	49,829,915.17	88.2
210104	Урамшуулал	51,534,300.00	66,542,350.00	(15,008,050.00)	129.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,667,000.00	169,878,620.14	9,788,379.86	94.6
210201	Тэтгэврийн даатгал	122,176,000.00	118,092,509.60	4,083,490.40	96.7
210202	Тэтгэмжийн даатгал	14,370,800.00	13,871,786.19	499,013.81	96.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,186,600.00	6,979,827.40	206,772.60	97.1
210204	Ажилгүйдлийн даатгал	7,186,600.00	6,259,096.08	927,503.92	87.1
210205	Эрүүл мэндийн даатгал	28,747,000.00	24,675,400.87	4,071,599.13	85.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,913,500.00	135,913,500.00	0.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	18,000,000.00	15,862,059.87	2,137,940.13	88.1
210302	Түлш, халаалт	94,713,500.00	94,714,064.00	(564.00)	100.0
210303	Цэвэр, бохир ус	23,200,000.00	25,337,376.13	(2,137,376.13)	109.2
2105	Нормативт зардал	175,899,500.00	172,299,270.00	3,600,230.00	98.0
210502	Хоол, хүнс	175,899,500.00	172,299,270.00	3,600,230.00	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	3,955,800.00	3,955,800.00	-	100.0

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	үйлчилгээний төлбөр, хураамж				
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,955,800.00	3,955,800.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,436,200.00	51,721,700.00	3,714,500.00	93.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,917,500.00	39,203,000.00	3,714,500.00	91.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,518,700.00	12,518,700.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,978,900.00	12,978,900.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,978,900.00	12,978,900.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,978,900.00	12,978,900.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,105,635,600.00	1,894,670,975.00	210,964,625.00	90.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,944,722,100.00	1,733,511,675.00	245,825.00	89.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,729,713,100.00	1,729,713,100.00	0.00	100.0
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	215,009,000.00	4,044,375.00	210,964,625.00	18.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,044,400.00	4,044,375.00	25.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	210,964,600.00	-	210,964,600.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	160,913,500.00	160,913,500.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	160,913,500.00	160,913,500.00	0.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	210,964,608.44	(210,964,608.44)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	178,600,686.38	(178,600,686.38)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	40	40	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	24	24	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1	1	-	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1	1	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь “Сургуулийн өмнөх боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших орчин, нөхцөлөөр ханган, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн сурч хөгжих , төлөвшихөд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.
- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай оролцох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,596,964.9 мянган төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	210,964.6	178,600.7	(32,363.9)
Авлага		15.1	15.1
Бараа материал	60,718.7	104,368.5	43,649.8
Үндсэн хөрөнгө	1,336,298.8	7,921,962.8	6,585,664.0
Нийт хөрөнгө	1,607,982.1	8,204,947.1	6,596,965.0
Өр төлбөр	5,877.6	5,058.5	-819.1

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,602,104.5	8,199,888.6	6,597,784.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,607,982.1	8,204,947.1	6,596,965.

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 178,600.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хэмнэлттэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 104,368.5 мянган төгрөг болж 43,649.8 мянган төгрөгөөр өссөн нь Боловсрол соёлын газраас 14,496.6 мянга, Боловсролын газраас 12,448,1 мянган үнэ төлбөргүй авсан бараа материалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,921,962.8 мянган төгрөг болж 6,585,664.0 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 179 дүгээр тогтоол, орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт зэргийг үндэслэн 5,527,039.8 мянган төгрөгийн цэцэрлэгийн шинэ байрны барилга, 1,074,385.3 бусад дагалдах үндсэн хөрөнгийг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,692,034.8 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 160,913.3 мянга, нийт 1,852,948.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 304,246.9 мянган төгрөгөөр бууруулж 1,387,787.9 мянган төгрөгөөр баталснаас тайлант онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,729,713.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 160,913.5 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 210,964.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,044.4 мянган төгрөг зэрэг **нийт 2,105,635.6 мянган төгрөгөөр** эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,729,713.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 160,913.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,044.4 мянган төгрөг, нийт 1,894,671.0 мянган төгрөг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,927,034.9 мянган төгрөг зарцуулсан байна.

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,927,034.9 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 150,938.2 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг 24,061.7 мянган төгрөгөөр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 3,600.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80233-Хүүхэд хамгаалал	1,854.7	1,854.7	0.0	100.0
2	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,650.7	3,650.7	0.0	100.0
3	81607-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	171,945.1	168,344.9	3,600.2	97.9
4	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	5,553.8	5,553.8	0.0	100.0
5	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	4,955.5	4,955.5	0.0	100.0
6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,688,040.1	1,537,101.3	150,938.8	91.1
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	64,677.8	40,616.1	24,061.7	62.8
8	818440-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	3,954.4	3,954.4	0.0	100.0
9	83603-Нэмэлт -Дээд шатны төсвөөс хуваарилсан	90.0	90.0	0.0	100.0
	Дүн	1,944,722.1	1,766,121.4	178,600.7	90.8
	Орон нутгийн төсвөөс				
10	8011-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	160,913.5	160,913.5	0.0	100.0
	Дүн	160,913.5	160,913.5	0.0	100.0
	Нийт дүн	2,105,635.6	1,927,034.9	178,600.7	91.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнаагүй, харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан /2024 оны

анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны зардлын 171,945.1 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,463,495.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,952.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 166 мэдээллээс дараах 5 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

- Төсвийн гүйцэтгэл /бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/ 1 сар;
- Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/ 1 сар;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/ 1 удаа;
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, /бүтэн жилээр/
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /сар бүр/.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.3.7, 6.4.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хүнсний 171,945.1 мянган төгрөгийн худалдан авалтыг нээлттэй шалгаруулалт зарлалгүйгээр Алтан тариа ХХК, Цахим ертөнц ХХК, Сэлэнгэ менежмент ХХК, Мөнх тужийн нарс ХХК, Гурван иш ХХК, иргэн Д.Далантай, Ч.Баярсайхан, Г, Оргил нартай тус тус шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт

өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 2: “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-100.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамруулаагүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	6,811.6	3	6,811.6	100.0
Зөвлөмж	2	-			
Нийт дүн	5	6,811.6	3	934.0	60.0

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан учир МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 751.8 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Ажил олгогчоос олгох ХЧТА тэтгэмжийг шууд зардлаар бүртгэсэн.

- Тайлант онд худалдан авсан угаалгын машиныг бусад бараа материалын дансанд бүртгэсэн.
- НДШ-ийн авлагыг өр төлбөрөөр бүртгэсэн.

Аудитаар нийт **24,101.8** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 3,481.4 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 5,058.4 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 15,562.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 11 багшид тус бүр 20 хувиар тооцон **2,647.8** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2.Хамтын гэрээнд тусгасан гэх үндэслэлээр ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангаагүй, эмчийн мэргэжилгүй, нярав Ц.Удвалаар 10,11 сард эмчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, 833.6 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/494, А/761 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт “Хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар”-ын в:Тавигдах шаардлага “**мэргэжил-хүний их эмч, бага эмч, сувилагчийн мэргэжлийн дипломтой**” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүйн улмаас хүнсний материалын болон аудитын төлбөрийн **5,058.4** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар ер төлбөр үүсгэхгүй ажиллах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Тус цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа нь өөрийн төрсөн охин Б.Чимгээг арга зүйчийн ажлыг хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл: "Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт"-ын 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах,.... гэрээ байгуулах.... зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах, Б.Чимгээг арга зүйчийн албан тушаалаас чөлөөлөх албан шаардлага хүргүүлэх.

3. Тус цэцэрлэг нь бага, дунд, ахлах, бэлтгэл зэрэг 24 бүлгийн хүүхдүүдийн ирцийг ангийн багшийн журнал, жижүүрийн ирцэд өдөр бүр 98.0-100.0 хувь ирснээр бүртгэж, хүнсний материалыг зарлагдсан байна. /нийт 170,235.3 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан/ Аудитын явцад зарим ангийн ирцийг түүвэрлэн тулган шалгахад ангийн журналд "Дунд Б" бүлэг 5 хүүхэд ирсэн байхад 17 хүүхэд ирснээр, "Дунд В" бүлэг 11 хүүхэд ирсэн байхад 17 хүүхэд ирснээр буюу хуурамчаар нэмэгдүүлэн бүртгэсэн байгаа нь тайлант оны хүүхдийн ирцийн бүртгэл, хоол хүнсний зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бодит тоо мэдээнд үндэслэн хүүхдийн хоолны материалыг зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Зайлшгүй шаардлагын улмаас цэцэрлэгийн орон тоонд батлагдаагүй бичиг хэргийн ажлыг хавсарсан гэх үндэслэлээр нярав Ц.Удвалд нэмэгдэл цалин хөлс олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Төсвийн

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

2.1 Илрүүлэлт: Нийт албан хаагчдын цалингаас 12 сард хамтын сангийн суутгал хийж нярав Ц.Удвалын дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно:” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалингаас зөвхөн хуульд заасан суутгалыг хийж байх.

2. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 15,562.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1: “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5: “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ажил олгогчоос олгох ХЧТА тэтгэмжийг шууд зардлаар бүртгэсэн	1	267.4			1	267.4	1	267.4				

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 онд худалдан авсан угаалгын машиныг бусад бараа материалын дансанд бүртгэсэн	1	469.9			1	469.9	1	469.9				
НДШ-ийн авлагаыг өглөгөөр бүртгэсэн.	1	14.5			1	14.5	1	14.5				
Дүн	3	751,8			3	751,8	3	751,8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бодит бус ирцээр хүүхдийн хоолны материалыг зарцуулсан.	1				1							
Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн	1	5,058.4			1	5,058.4						
Хамаарал бүхий этгээдийг албан тушаалд томилох шийдвэр гаргасан	1				1							
Нярваар эмчийн ажлыг хавсруулан ажиллуулсан	1	833.6	1	833.6								
Ур чадварын нэмэгдлийг илүү олгосон	1	2,647.8	1	2,647.8								
Хандивын бараа материалыг бүртгэл, тайланд тусгаагүй	1	15,562.0					1	15,562.0				
Цэцэрлэгийн орон тоонд батлагдаагүй бичиг хэргийн ажлыг няравт хавсаргаж нэмэгдэл цалин хөлс олгосон	1						1					
Цалингаас хамтын сангийн суутгал хийсэн байна.	1						1					
Дүн	8	24,101.8	2	3,481.4	3	5,058.4	3	15,562.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 4 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1				1			
Дүн	1				1			
Нийт дүн	2				2			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 155/А/1850385

Сүхбаатар

УОА-2025/122/НА-СТА-7413

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бага, дунд, ахлах, бэлтгэл зэрэг 24 бүлгийн хүүхдүүдийн ирцийг ангийн багшийн журнал, жижүүрийн ирцэд өдөр бүр 98.0-100.0 хувь ирснээр бүртгэж, хүүхдийн хоолны зардалд 170,235.3 мянган төгрөгийг зарцуулснаар тайлагнасан байна. Аудитын явцад зарим ангийн ирцийг түүвэрлэн тулган шалгахад ангийн журналд “Дунд Б” бүлэг 5 хүүхэд ирсэн байхад 17 хүүхэд ирснээр, “Дунд В” бүлэг 11 хүүхэд ирсэн байхад 17 хүүхэд ирснээр буюу хуурамчаар нэмэгдүүлэн бүртгэсэн байгаа нь тайлант оны хүүхдийн ирцийн бүртгэл, хоол хүнсний зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ” 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Хүүхдийн ирцийг бодитоор тооцож, хүүхдийн хоолны материалыг зарцуулаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, нягтлан бодогч Б.Дархижав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

ДАРИУНАА



432504463



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 1571/АБДЗХЗ

Сүхбаатар

УАА-2025/122/НА-УАА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар тус цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа нь өөрийн төрсөн охин Б.Чимгээг арга зүйчийн ажлыг хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд "Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт"-ын 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах,.... гэрээ байгуулах.... зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: " 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Б.Чимгээг арга зүйчийн албан тушаалаас чөлөөлөн, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, нягтлан бодогч Б.Дарихжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504460



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 43/А/БДЗХБ

Сүхбаатар

ПА-2025/122/НА-СТА-743

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хэвсрэлтын 2.Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-100.0 сая” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.Үүнд: ” 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, нягтлан бодогч Б.Дархижав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА
Д.АРИУНАА

432504430

Handwritten text, possibly a signature or initials, located in the lower center of the page.

635206630



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 60/А1850385
107-2025/122/НА-СТА-ТМЗ

Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хамтын гэрээнд тусгасан гэх үндэслэлээр эмчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангаагүй, эмчийн мэргэжилгүй нярав Ц.Удвалаар эмчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, 833.6 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/494, А/761 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт "Хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар"-ын в:Тавигдах шаардлага "мэргэжил-хүний их эмч, бага эмч, сувилагчийн мэргэжлийн дипломтой" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3: "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Үндэслэлгүйгээр олгосон 833.6 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
- Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, нягтлан бодогч Б.Дарихжав нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432505179



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 59/АБДЗ85

Сүхбаатар

100-2025/122/НА-СТА-ТМС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, сум, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр хавсралтад дурдсан 11 багшид 15-20 хувиар тооцон ур чадварын нэмэгдэлд 2,647.8 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь "Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. "цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь", "сумын түвшинд 15 хувь" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3: "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндэслэлгүйгээр олгосон 2,647.8 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, нягтлан бодогч Б.Дарихжав нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432505173

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын
2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
59/А.125.03.25 дугаар актын хавсралт



Үндэслэлгүйгээр олгосон ур чадварын нэмэгдэл

/мянган төгрөгөөр/

№	Албан хаагчийн овог, нэр	Албан тушаал	Мөнгөн дүн
1	Б.Чимгээ	Багш	294.2
2	Э.Анхзаяа	Багш	294.2
3	Х.Баярмаа	Багш	294.2
4	О.Анхтуяа	Багш	294.2
5	Ц.Жавзандулам	Багш	294.2
6	О.Ариунтуяа	Багш	147.1
7	Я.Саруулцэцэг	Багш	147.1
8	Ч.Ундармаа	Багш	294.2
9	Л.Уянга	Багш	294.2
10	Ц.Энхтуяа	Багш	147.1
11	Ц.Болорцэцэг	Багш	147.1
	Нийт дүн		2,647.8